



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 2008

Улаанбаатар хот

**Н.Бат-Ирээдүйд сахилгын
шийтгэл ногдуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.2, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын 5.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 10.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн 10 дугаар хорооны улсын бүртгэгч Нэргүйн Бат-Ирээдүй нь Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид дараах бичиг баримтыг бүрдүүлж, гэрлэсний бүртгэлд өөрийн биеэр бүртгүүлнэ”, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 3.1 дэх заалтад “Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан гэрлэсний бүртгэлийг хөтлөхөд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг баримтлана” гэж заасныг зөрчиж гэрлэсний бүртгэлийг хөтлөн албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан нь хяналтын улсын байцаагчийн 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 711 тоот дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд албан тушаалын цалингийн хэмжээг 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандaa холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Н.Бат-Ирээдүйд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс /Д.Оюунбилэг/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Б.БААСАНДОРЖ

571001868

5200722 1118266215